



## “Цаг хугацаа орон зайг үл хамаарах Эрх мэдэлт хүчит залбиралаар ДОХ өвчнөөс эдгэрсэн нь”

Леопард итгэгч (АНУ, Нью Йорк Олон Улсын Манмин Сүм)

2009 оны Зургадугаар сард миний бие маш доройтов. Ихээр ханиалган арьсны өвчин бүх биеэр минь туурч гарсан юм. Би өвчнөөсөө эдгэрэх гэж нэр хүнд бүхий маш олон пасторуудаас залбирал авсан боловч ямар ч тус болоогүй юм.

Нью Йоркын Бруклины төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт орсон ба үзлэгийн үр дүн нь “Уушгины сүрьеэ ба Дох” хэмээн гарав. Тэгээд эмнэлэгт хүчтэй эм тариагаар эмчилгээ хийж байсан ч улам бүр дордоор байлаа. Бүр амьсгаа авахад ч хүртэл хэцүү зовлонтой байсан юм.

Хэдий тийм ч би дотроо “Бурхан юуг л бол юуг анагаах чадалтай” гэсэн найдлага минь байсаар л байсан. Тэгж байтал Доктор И Жаерок пастор оров. Доктор И Жаерок пасторын Перу нэгдсэн их цуглаан болон Нью Йоркын нэгдсэн цуглаан бичлэгийг найзын маань ээж нь надад хоёр жилийн өмнө өгсөн үзэв. Үзэж байхад Түүний хүч нь надад үнэхээр гайхлыг төрүүлэв.

2009 оны Наймдугаар сараас эхлээд Манмин төв сүмийн сайт Манмин

ТВ-гийн үзэж эхлэв. Доктор И Жаерок пасторын сургаалуудыг сонсож байхад яг надтай нүүр нүүрээ харан ярьж байгаа мэт санагдаж байсан тул нулимс дуслуулан анхааралтайгаар сонсов.

Ялангуяа И Жаерок пасторын залбирлаар хараагүй хүмүүс хараа орж, сонсоогүй хүмүүс, сонсогтой болж, төрөл бүрийн өвчнөөс эдгэрч, тэргэнцэр дээр сууж байсан хүмүүс босож гүйх зэрэг гайхамшигт эрх мэдэлт хүчний нөлөө гарч байгааг үзээд би ч гэсэн ингэж эдгэрэх боломжтой гэсэн найдвар минь улам хүчтэй болов. Мөн түүнчлэн Дуулал 62:11-д “Хүч чадал бол Бурханых” хэмээн айлдсан байдаг шиг Доктор И Жаерок пастор бол үнэхээр Бурханы хүч гэдэгт итгэв.

Тиймээс би одоо дахин эмнэлэг рүү явахгүйгээр шийдсэн юм. Өдөр бүр интернэтээр Доктор И Жаерок пасторын сургаалыг сонсч өвчтэй хүмүүст зориулсан залбирлыг авч байлаа. Бага багаар өвчин хөндүүр арилж бие тэнхэрч байгаа нь мэдрэгдэв. Тэгээд би мацаг барин

залбиран Бурханаас зуурахад миний сэтгэл зүрх амар тайван ба баяр хөөрөөр дүүрэн байсан билээ.

2010 оны Аравдугаар сарын 16 нь миний төрсөн өдөр байсан юм. Тэр өдөр ч гэсэн үүрийн 5 цагын үед би Доктор И Жаерок пастор өвчний төлөө залуу бирыг авахад миний бүх бие халуу дүүгэж эхэлсэн бөгөөд хөлс гарч бүх бие минь нойтон болсон юм.

Дараагийн өдөр нь би эмнэлэг явсан. Эмч бүх шинжилгээг авч дуусаад хариуг нь хараад маш их гайхав. Дох ба уушгины сүрьеэгийн шинж тэмдэг ор мөргүй алга болсон байлаа. Эмч маань бүр итгэж ядан намайж өөр эмнэлэг дээр очиж шинжилгээ дахин өгөхийг зөвлөв. Хэдий тийм боловч шинжилгээний хариу нь бас өмнөхтэйгээ адил байв. Халлелүя!

Одоо би Нью Йоркын Манмин Сүмд (Пастор Шим Жамес) үнэхээр аз жаргалтай байна. Цаг хугацаа орон зай үл хамааран эрх мэдэлт хүчит залбирлаар эдгээж өгсөн Бурхандаа талархал ба алдрыг өргөө!

## “Би толинд харах болгондоо аз жаргалтай”

Бямба Нямсүрэн эгч дүү (Монгол Манмин Сүм)

Би сүүлийн үед толинд харах болгондоо аз жаргалаар дүүрэн байна. Учир нь толгойн үс халцарч унадаг өвчнөөс эдгэрч өмнөхөөс ч илүү эрүүл бат бөх үс ургаж ирсэн тул би маш их аз жаргалтай.

2010 оны Аравдугаар сарын 1-нд толгойны оройн хэсэг зулайгаас эхлээд үс маань унаж эхлэв. Үс унасаар л байдал улам дордож эхлэхэд би үсээ хууулан хиймэл үс зүүдэг болов. Үүндээ би их шаналж сэтгэлээр унаж байлаа. Гэвч өнгөрсөн жилийн 5 сараас эхлэн би Монгол Манмин Сүмд очиж эхэлснээс хойш олон гайхамшигт эдгэрлийн гэрчлэлүүдийг үзсэн тул би ч өөрийн толгойн үс унах өвчнөөсөө эдгэрнэ гэдэгтээ итгэлтэй байлаа.

Мөн тухайн үед миний бөөр их

өвдөг байсан ба өвчнийхөө улмаас сайн унтаж чадахгүй байсан тул би гэртээ тариа тариулдаг байв. Тэр үед Манмин Төв Сүмээс Жү Хёонг вон пастор ирээд Гар алчуурын цуглааныг (Үйлс 19:11-12) манай сүмд хийсэн юм. Би тэр цуглаанд оролцон залбирал аваад эдгэрсэн юм.

2011 оны 1 сард, би “Яагаад миний үс унаад байгаа юм бол?” хэмээн бодох бөгөөд өөрийн амьдралаа эргэн харж 10 хоног мацаг барьж залбирч байхад зуур хамаатны эгчийгээ хайрлаж чадалгүй, хуурч мэхлэн, хааяа худал ярьдаг байсан минь санагдаж үнэхээ чин сэтгэлээсээ гэмшсэн юм.

Тэгээд Нэгдүгээр сарын 29-нд, Монгол Манмин Сүмийн хариуцагч Батзориг Сайн мэдээ тунхаглагчын

улирдан явуулсан гар алчуурын цуглаанд оролцон залбирал авсан юм. Энэ үед Ариун Сүнсний гал бууж ирэн миний бие минь халуу дүүгэхийг мэдрэсэн юм. Үүний дараагаар миний үс дахин ургах эхлэн 3-р сар гэхэд би хэвийн байдалд орсон байв.

Илүү талархалтай зүйл нь миний үс бүр урьдныхаасаа илүү өнгөлөг бөх бат болсон ба салаалдаггүй болсон юм. Ингэж Бурханы агуу хүч чадлыг дахин нэг удаа мэдэрсэн бөгөөд үргэлж талархал дотор баяр хөөртэйгөөр амьдарч байна. Амьдралын жинхэнэ утга учрыг мэдэхгүй төөрөлдөж яваа үй олон хүмүүст



Эзний хайрыг дамжуулдаг ажилтан болохыг маш ихэд хүсч байна.



Бямба Нямсүрэн эгч дүү толгойн үс халцарч өвчнөөсөө гар алчуурын залбиралыг хүлээн авч эдгэрэв (Үйлс 19:11-12). Түүний үс нь урьдныхаасаа илүү эрүүл бөх бат болов.

Мөргөлийн цаг		Залбирлын цаг		
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Их мөргөл	Ням гариг 10: 30	Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаая (Том хүний баг хариуцагч)
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40	Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00	Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00			
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30			
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30			

**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С

**Утас:** чуулганы- 5525-7637  
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org

# Манмин Мэдээ

Дугаар 14 2011 оны наймдугаар сарын 07

## 22 орны хэлээр орчуулагдан гарсан, бүх дэлхий даяар заавал унших ёстой ном “Загалмайн Үг”

Үй олон хүмүүсийг сүнс зүгийн унтаа байдлаас нь сэрээж, жинхэнэ амь амьдралыг өгч буй сэтгэл хөдлөм гайхамшигт сайн мэдээ “Загалмай Үг”

Доктор Жаерок Лее пасторын бичсэн гайхамшигт номуудын нэг болох “Загалмайн Үг”-ыг бүх дэлхий даяар, хүн болгоны заавал унших ёстой номын тоонд зүй ёсоор орсон юм. Дэлхий нь өнцөг булан бүрт энэхүү “Загалмайн Үг” номыг уншиж ивээл хүртсэн пастор Эзэний боолууд ба итгэгч нарын талархалын олон мянган захидлууд тасралтгүй ирсээр байгаа билээ. Мөн олон пасторууд энэхүү номыг өөрсдийн сүмдээ зааж сургахын тулд түүнчлэн өөрсдийн хэлээр орчуулагдан гаргах талаар хүсэлтүүд олширсоор байна. Учир нь энэ ном бол итгэлийн амьдралд хамгийн чухал хэрэгтэй сургаал үг учраас юм.

Энэ жил 4 сард “Загалмайн Үг” Вьетнам хэл дээр хэвлэгдэн гарсан ба одоогын байдлаар Солонгос, Англи, Хятад (Орчин Цагын) Франц, Орос, Испани, Герман, Япон, Дагалоог, Араб, Вьетнам, Естони, Урду, Итали, Индонейз, Тамил, Хинди, Тайланд, Финланд, Еврей болон Непаль хэмээх нийт 22 хэлүүд дээр нийтлэн гаргаж байгаа билээ. Одоогийн байдлаар Грек, Монгол, Португал зэрэг хэлүүд ба үүнээс гадна 16 хэл дээр орчуулагдан хэвлэлтэнд бэлтгэгдэж байгаа бөгөөд Англи хэлнээс Армени, Иран гэх мэт нийт 10 хэл дээр орчуулгын ажил явагдаж байгаа билээ.



билээ.

Энэхүү номд Бурхан хүн төрөлхтөнийг аврах авралын төлөвлөгөө болох “Бурхан Сайн мууг мэдүүлэгч модыг Еден Цэцэрлэгт тавьсны утга учир?”, “Есүс яагаад бидний цорын ганц Аврагч юм бэ?” “Есүсийн загалмайн дээр хэлсэн долоон үгийн утга юу юм бэ?” хэмээх асуулуудын

хариулт ба авралын утга Бурханы хүн төрөлхтөний боловсруулан хөгжүүлэлтийн тухай маш тодорхой хариулж өгсөн байдаг. Энэ дундаас “Бурхан сайн мууг мэдүүлэгч модыг яагаад тавьсны” учрыг л ойлговол үүний хамт олон зүйлсийг ухааран Бурханыг гал халуунаар хайрлахгүй байхын аргагүй юм. Цаашилбал хүн

төрөлхтөнийг аврах авралын төлөвлөгөөний тухай ухаарах үед Бурханы хайр ба мэргэн ухааныг бишрэн магтахгүй байх аргагүй юм гэдгийг ойлгох болдог билээ. Түүний номууд нь Библи дээр тулгуурласан байдаг ба түүний сургаалууд нь Есүс Христийн тухай хувирашгүй бат итгэлийг агуулсан байдаг билээ.”

би урьд өмнө хараагүй юм. Түүний ном болох “Загалмай Үг” мэдээж миний амьдралыг болон Нью Йоркын хүмүүсийн амьдралыг өөрчилсөн билээ. Цаашилбал энэ ном төдийгүй Түүний сүмийн бүх үйл ажиллагааг дэмжихийг хүсч байна. Энэ ном нь улс орон төдийгүй бүх дэлхий даяарх сүмүүдийг өөрчлөн сэргээх чадвартай билээ” гэж дурьдан хэлж байлаа.

Мөн Испанид “Нүеба Вида” хэвлэлийн байгууллагын ерөнхийлөгч Хосе Рикардо, “Энэ ном нь библи дэх ишлэлүүдийг гүнзгий тайлбарласан ба миний уншсан номуудын дотроос хамгийн шилдэг сайн мэдээний ном бөгөөд уншигч олны хайр ба талархлыг хүртсээр байгаа билээ.” хэмээн дурдан хэлсэн байдаг. АНУ-аас Доктор Ричард Блайк Амазон.com сайт сэтгэгдлээ үлдээхдээ “И Жаерок пастор нь “Загалмайн Үг” хэмээх номоороо дамжуулан уншигч олонд Бурханы хязгааргүй их хайр ба гайхамшигт төлөвлөгөөг гүнзгий ойлгуулж өгөн, итгэлийн суурийг баттай тавьж өгдөгөөрөө онцлог юм.

## Энэтхэг Ченнай Манмин сүмийн залуучуудын зуны цуглааны тухай



Зургадугаар сарын 2-нд, Энэтхэг Ченнай Манмин Сүмийн хариуцагч Хан Жон хи Пасторын удирдлагаар Залуучуудын зуны цуглааны арга хэмжээ Энэтхэг улсын Күенсэнд болж өнгөрөв.

“Шавар Сав” хэмээх сэдвийн дор нээгдсэн энэ удаагийн зуны цуглаанаар залуучууд маань өөрсдийн хүсэл мөрөөдөл ба ирээдүйн зорилгын талаар саналаа хуваалцаж, Бүтээгч Бурханаас өөрөөр нь дамжуулан биелүүлэх гэсэн зүйл нь юу болохыг дахин нэг ухаарсан цаг байлаа.

Тус газар цаг агаар бараг 40 хэмийн халуун байсан ч И Жаерок Тэргүүн пасторын залбирлыг аван зуны цуглааны үйл ажиллагаа явагдахад Бурхан нарыг үүлээр халхлан өгч сэрүүн сэвэлзүүр сайхан салхитай байсан бөгөөд нарыг тойрсон тойрог хэлбэртэй солонгыг харах боломжтой байсан юм.



“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд (12)

# Эдгээгч Их Эзэн

“Биднийг нүгэлд үхүүлж, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр Өөрөө бидний нүглийг модон дээр биедээ үүрсэн. Учир нь та нар Түүний шархаар эдгээгдсэн билээ” (1 Петр 2:24).

Бурханы жинхэнэ үр хүүхэдтэй болохын тулд төлөвлөсөн төлөвлөгөөний дунд хамгийн чухал хэсэг болох Есүс махан биеэр энэ газар дээр ирээд төрөл бүрийн зовлон болон загалмайд цовлогдон хүн төрөлхтөнийг аврах авралын замыг төгс нээж өгсөн юм. Энэ удаад эдгээрийн лундаас Есүс ташуурдуулан цусаа урсгасан нь ямар учиртай болохыг авч үзэцгээ!



Доктор И Жаерок Тэргүүн Пастор

ташуурдуулан цусаа урсаж биднийг ямар ч өвчин зовлонгоос чөлөөлж өгсөн билээ.

## 2. Эдгээгч Их Эзэнтэй уулзъя гэвэл нь

1 Петрийн 2:24-н сүүл хэсэгт “Учир нь та нар Түүний шархаар эдгээгдсэн билээ” хэмээн айлдсан байдаг. Тиймээс Есүс ташуурдуулан цусаа урсгаснаар өөрийгөө ямар өвчнөөс чөлөөлөгдсөн гэдэгт итгэдэг хүн бүр дахин өвчнөөс болж зовох шаардлагагүй юм (Матай 8:17).

Зарим хүмүүс, “би сул дорой тул гэм нүгэл үйлдэх үе байдаг. Хүн төгс биш учраас Бурханы үг сургаалын дагуу амьдрах нь маш хүнд зүйл” хэмээн хэлдэг. Өөрсдийгөө “Би сул дорой” гэвэл сул дорой байхаас өөр аргагүй, “Гэм нүгэл хаях нь хэцүү” гэвэл итгэлийн амьдрал хүнд хэцүү байхаас өөр аргагүй билээ. Сургаалт Үгс 18:21-д “Амь ба үхэл нь хэл ярианы хүчинд байдаг. Түүнд дуртай хүн эдгээрийн үр жимсийг хүртдэг.” хэмээн айлдсантай адил билээ.

Ямар ч нөхцөл байдалд орсон ч гэсэн эрхэм та, “Би чадна, Бурханы ивээлээр хүчирхэг,бялхаж байна” гэж амаараа тунхаглавал энэ итгэлийн тунхаглагласны тань дагуу эрхэм та Бурханы ивээл хүч чадлыг хүлээн авч өчүүхэн ч ядралгүй “боломжгүй” зүйлийг ч хүртэл “боломжтой” болгон өөрчилж болдгийг харж болно. Мөн эрхэм та өвчин эдгэрлийн залбирлыг авсны дараа “Би эдгэрлийн залбирал авсан юм чинь эдгэрэх болно” хэмээн бодохын оронд “эдгэрлийн залбиралаар би аль хэдийнээ эдгэрсэн билээ” хэмээн итгэвэл Бурхан таны итгэлийн дагуу гайхамшгаа үйлдэх билээ.

Зарим хүмүүс “залбирал авсан ч одоо хүртэл өвдсөөр байхад яаж би өөрийгөө эдгэрсэн гэж бодох билээ? Энэ нь би худлаа хэлж байгаа үг биш гэж үү?” гэдэг мэдээж худлаа ярь гэж хэлж байгаа юм биш хэрвээ энэ хүн сүнслэг итгэл гэж юу болохыг мэддэг бол үүнийг ойлгох юм. Еврей 11:1-д, “Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдлыг, харагдахгүй зүйлсийн баталгаа юм.” хэмээн айлдсан байдагчлан итгэл нь хэдийнээ бий болсон зүйлийг хараад гэрчлэх бус харин харагдахгүй зүйлсийг итгэлээрээ шийдэх үед бодитоор биелэгдэхийг хэлж байгаа юм.

Тэглээ гээд зүрх сэтгэлд нь итгэгдэхгүй байхад хэл амаараа “Би итгэж байна” гэж хэллээ гээд тэрчлэн бүтдэг гэсэн үг бас биш юм. Зүрх сэтгэлдээ жинхэнээсээ итгэгдсэн итгэлээ амаараа тунхаглах үед л тэр нь бодитоор бий болдог болохыг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн өвчнөөсөө эдгэрэх тухай ч мөн үүний адил гэж хэлж болох билээ. “Бурханы хүч чадлаар өвчин сул дорой байдал надаас зайллаа” гэж зүрх сэтгэлдээсээ итгэн амаараа тунхаглавал энэ итгэлийнх нь дагуу Эзэнээс нөлөөлж өгдөг билээ. Энэ нь бидний өвчин сул дорой байдалаас чөлөөлөхийн төлөө Эзэн ташуурдуулан цусаа урсгасан учраас юм. Тиймд үүнд итгэхгүй, итгэлээр тунхаглаж ч чадахгүй бол урьдын хэвээрээ л сул дорой байдалдаа өвчтэй байсаар л байдаг. Залбирал авлаа ч гэсэн “Би өвдөж байна. Арай л эдгээгүй юм шиг байна.” гэдэг учир мөн л урьдын хэвээр өвдсөөр л байдаг. Ийм өвдрөг бус бодол санааг хагалж хаяхгүй бол Бурханы агуу хүч чадлыг мэдрэх боломжгүй гэдэг нь үнэн билээ.

## 3. Итгэж байна гэсэн мөртлөө эдгэрч чадахгүй байдгийн учир шалтгаан

Есүсийг ташуурдуулснаар бид өвчнөөсөө чөлөөлөгдсөн гэдэгт итгэдэг гэсэн мөртлөө урьдын хэвээр өвчнөөсөө болж байгаа хүмүүс нь Бурханы үнэн зөвийг дагахгүй байгаагаас болж байгаа юм.

Египетээс гарсан нь 15:26-д, “Тэр -Хэрэв та нар өөрсдийн Бурхан ЭЗЭНий дуу хоолойг анхааралтай сонсож, Түүний мэлмийд зөвийг үйлдэж, Түүний тушаалуудад чих тавьж, Түүний бүх тогтоолыг сахивал, Би египетчүүдэд буулгасан өвчнүүдээс нэгийг нь ч та нарт буулгахгүй. Учир нь ЭЗЭН Би бол та нарыг эдгээгч билээ гэв.” хэмээн дурдан бичсэн байдаг. Энд Египет гэдэг нь сүнс зүгийн утгаар энэ дэлхий ертөнцийг хэлж байгаа бөгөөд Египетээс Израйль чууд гарах тэр үед Египт дээр 10 гай гамшиг буулгасан ба үүнийг сүнслэг утга нь дэлхий ертөнцийн бүх л өвчнүүдийг ерөнхийд нь нэрлэж байгаа билээ.

Тиймээс бид Бурханы тушаалуудыг сахин биелүүлбэл ямар ч өвчин тусгахгүй бөгөөд магадгүй туслаач гэсэн өөрийгөө эргэн харан гэмшвэл “ЭЗЭН Би бол та нарыг эдгээгч билээ” айлдсанчлан Төгс хүчит Бурхан Аав хангалттай эдгээж өгөх билээ. Гэхдээ намайг харахад зөвийг бус харин Бурханы зөвт байдлыг үйлдэх ёстой билээ.

Хүн бүрийн зөвт байдал гэж үзэх үзэл нь өөр өөр байдаг нь бүх хүмүүс төрөөд хэсэг хүртлээ харсан, сонссон, сурсан зүйлс нь өөр өөр, өсөж торнисон нөхцөл байдал нь ч өөр учраас юм. Энэ хүний зөв гэсэн зүйлийг тэр хүнийг харахад зөв бус харин ч бүдүүлэг ёс бус байдал ч байж болох юм. Жинхэнэ үнэн болсон Бурхан үгээр л зөвт байдлыг хэмжих ба Бурханаас зөв хэмээн хүлээн зөвшөөрсөн зүйл нь жинхэнэ зөв зүйл юм

Жишээлбэл, нэг айлын хүүхэд гэртээ найзуудаа зодуулан хүрч ирэхэд тэр

хүүхдийн эцэг эх уурлах эсвэл тэр хүүхдийн эцэг эхтэй нь уулзахаар явж магадгүй. Харин Үнэн Бурханы зөвт байдал нь “Баруун хацрыг алгавал зүүг хацраа тавьж өг, Эвтэй бай. Дайснаа ч хүртэл хайрла” хэмээн айлдсан байдаг. Эрхэм та Бурханы зөвт байдлыг дагах үед анхандаа хохирол амсаж байгаа мэт боловч эцэстээ Бурханаас хүлээн зөвшөөрч өргөмжилж өгдөг юм.

Зарим хүмүүс, “Бурханы сургаалуудыг яаж бүгдийг нь дагах боломжтой юм бэ?” хэмээн хэлцгээж байдаг. Үнэндээ Бурханы сургаалыг даган мөрдөж амьдрах нь тийм ч хэцүү зүйл биш юм.” Ариун сүнснээс тусалбал, Бурханы өгсөн ивээл ба хүчээр хангалттай хийж чадна” гэж итгэн хийвэл туйлын амархан билээ. 10 хууль, Ариун Сүнсний 9 үр жимс, хайрын бүлэг, 8-н ерөөл бүгдийг нь биелүүлбэл Бурханыг харахад зөвийг үйлдэх бүрэн боломжтой юм.

Шастирын Дэдийн 16-р бүлэгт Өмнөд Иудагийн Аса хаан эхэндээ Бурханд үнэнчээр үйлчилдэг байснаа эцэстээ зүрх сэтгэл нь хувирч гэм нүгэл үйлдсээр хурааснаар хөлдөө аймшигт хүнд өвчнөөр өвчилж орхидог юм. Энэ үед ч гэсэн гэмшин Бурханаас зураха ёстой байтал дэлхийн бариагч домч нарыг түшиглэснээр эцэстээ үхдэгийг харж болно.

Одоо үед ч гэсэн маш олон хүмүүс, “Бүхнийг бүтээгч,Төгс хүчит бөгөөд амь ба үхэл хийгээд бүгдийг Захирагч Бурханд итгэж байна гэгцгээдэг хэрнээ яг хүнд хэцүү зүйл тохиолдвол дэлхийн ямар нэгэн зүйл рүү найддаг хүмүүс олон байдгыг харж болно. Бурханы үг сургаалыг их сонссон мэддэг ч гэсэн хууль, тушаалыг сахихгүй юм бол эдгэрэх боломжтой сүнс зүгийн итгэл мэдээж ирэхгүй билээ. Ариун Сүнсний хүлээн аван, Бурханы хүүхдийн эрхийг авч харанхуйгаас гарч гэрэл ба зөвт байдал дотор үйлдэн, Бурхан ба та 2ийн өмнө байгаа гэм нүглийн ханыг нураах тусам итгэх итгэлтэй болж, Бурханы хүч чадлыг мэдрэх боломжтой билээ. Өвчин ч тусахгүй бөгөөд магадгүй туслаач ч гэсэн хэдийн эдгэрсэн гэж итгэвэл тэр даруй асуудал шийдэгдэх болно.

Хайрт итгэгч, ах эгч дүү нар аа, Есүс бидний сул дорой байдал бүхий л өвчнөөс чөлөөлж өгөхийн төлөө ташуурдуулан цусаа урсгасан билээ. Тийм болохоор бид Бурханы тушаалыг хичээнгүйлэн дагаж мөрдөж, Бүхнийг чадагч Бурханыг ямар ч үед найдан түшиглэснээрээ Бурхандаа алдрыг өргөхийг Их Эзэний нэрээр хүсэн өрөө!


**Mongolian**

**Манмин Мэдээ**

Published by Манмин Төв Цүм

---

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
e-mail: manminministry@hotmail.com  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин



Хайрын Бурхан анхны хүн Адамыг бүтээгээд түүнд зориулан тохирох туслагчыг бүтээж өгсөн билээ.(Эхлэл2:18). Энэ нь тэд хоорондоо ярилцаж, зарим үед тайвшруулж, бие биэндээ хайрыг өгч авалцаж гэж Бурханы тэдэнд санаа тавьсан хэрэг юм. Гэтэл дэлхийд гэм нүглээр дүүрэх үед гэр бүлийн харилцаа ч гэсэн Бурханы анхнаас тогтоосон хүслийнх нь дагуу бус маш их өөрчлөгдөн зөрчилдөөнтэй болсон юм. Бурханы хүсэл таалалд нийцсэн гэр бүлийн харилцаа болон эхнэр нөхрийн үүргийн үзэхдээ үүгээр дамжуулан хайр ба аз жаргалаар дүүрэн гэр бүл болохыг хүсэн өрөө!

## ▼ Эхнэр нөхөр нь бие биендээ маш эрхэм чухал бүтээл

Эхлэлийн номонд, эмэгтэй хүний үүслийн талаар дурдан бичсэн байдаг. Эхлэлийн 2:21-22-д, “ЭЗЭН Бурхан Адамыг гүн нойронд автуулж, түүнийг унтаж байх зуур хавиргаас нь нэгийг сугалж аваад, ормыг нь махаар бөглөжээ. ЭЗЭН Бурхан Адамаас авсан тэр хавиргаараа эмэгтэй хүн бүтээгээд, түүнийгээ Адамд авчирч өгөв” хэмээн айлдсан байдаг.

Яг эмнэлэгт өвчтөнд мэс засал хийхийн өмнө унтуулан мэдээ алдуулдаг шиг Бурхан Адамыг өвдөлтийг мэдрүүлэхгүй тулд гүн нойронд автуулан түүний нэг хавиргыг авдаг. Хавирга нь хүний бие махбодийн төв хэсэгт байрласан байдаг ба зүрх, уушиг болон ходоод гэдснийг хамгаалж байдаг. Хүний биений төв дунд цээжин хэсэгт байдаг учраас энэ хэсэгт хүчтэй цохилт авах үед хавирга нь энэ цохилтонд тэсвэртэй бөгөөд дотор эрхтнүүдийг бүрэн хамгаалдагаараа онцлогтой юм.

Бурхан эмэгтэй хүнийг эр хүний хавиргаас бүтээсний учир нь гэвэл эмэгтэй хүн нь эрэгтэй хүний хувьд нэн чухал бүтээл болохыг ойлгуулахын тулд юм. Энэ нь эрэгтэй хүн бол тохирох туслагч эмэгтэйгүйгээр байж болшгүй бүтээл ба тийм хэмжээний чухал үүргийг гүйцэтгэдэг гэсэн үг юм. Тиймээс Адам нь Эхлэл 2:23-д, “Энэ бол яснаас минь авсан яс, махнаас минь авсан мах” хэмээн Еваг хараад тийнхүү хэлсэн билээ. Тиймээс эхнэр нөхөр 2нь бие биендээ маш эрхэм чухал бүтээл юм.

## ▼ Нөхөр нь эхнэрээ өөрийн бие шигээ эрхэмлэн хайрлах хэрэгтэй

Эмэгтэй хүний уг үүсэл нь эрэгтэй хүнээс гарсан учраас нөхөр нь эхнэрээ хайрлана гэдэг нь эцэстээ өөрийгөө хайрлаж байгаатай адил юм (Ефес 5:28). Мөн Ефес 5:25-д, “Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла” гэж айлдсан байдаг билээ. Хүргэн болсон Эзэн минь үзэсгэлэнт бэр мэт итгэгчдийн төлөө амиа хүртэл зориулсан билээ. Тиймээс ийм Эзэний хайрыг дуурайн нөхрүүд эхнэрээ энэ мэт хайрлах хэрэгтэй.

1 Петр 3:7-д, “Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэн та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийн хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ. Ингэвэл та нарын залбиралд саад тогтор учрахгүй” хэмээн дурдагдсан байдаг.

Эхнэр нь нөхрийнхөө хамгийн амин чухал хэсэг боловч нөхрөөсөө ч илүү эмзэг сул дорой сав юм. Тиймээс нөхөр эхнэрээ өөрийн бие шигээ хайрлан эрхэмлэх үед Бурхан нөхрийнх нь залбиралыг нь сонсож өгдөг билээ Тийм ч учраас Колоссай 3:19-д, “Нөхрүүд ээ, эхнэрээ хайрлагтун. Тэдэнд бүү хатуу ханд.” хэмээн айлдсан байдаг.

Нөхөр нь эхнэрээ хайрладаг бол зохисгүй авирладаггүй ба уурлаж усаарладаггүй ба харин ч өөрийн эрх ашгаас илүү эхнэрийгээ эрх ашгийг биелүүлж өгөн бүх зүйлийг тэсвэрлэн, бүгдэд итгэн найддаг билээ. Хэдийгээр алдаа дутагдал байлаа ч халхлан хамгаалах билээ. Бурхан Адамд эмэгтэй хүнийг өгсөн нь сүнс зүгийн хайрыг хуваалцахыг хүсэн учир юм.

## ▼ Эхнэр нь нөхөртөө хүндэтгэн үйлчлэн Эзэн дотор дуулгавартай хэрэгтэй

Бурхан эмэгтэй хүнийг зүгээр нэг шорооноос бүтээгээгүй эрэгтэй хүнээс бүтээсэн билээ. Энэ нь эхнэр нөхөр нь нэгэн бие гэсэн үг юм. Мөн түүнчлэн, эрэгтэй хүн гол шийдийг гаргаж байдаг ба эмэгтэй хүн түүнд тусалж байдгийг үзүүлж байгаа юм.

Гэр бүлдээ эхнэр нь нөхөртөө хүндлэн үйлчилж, мөн нөхөртөө дуулгавартай байвал зохино. Ефес 5:24-д, “Чуулганууд Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд” гэсэн бол Колоссай 3:18-д, “Эхнэрүүд ээ, Эзэний таалалд нийцүүлж нөхөртөө захирагдагтун” хэмээн дурдсан байдаг.

Мэдээж энд яригдаж буй дуулгавартай байх гэдэг нь “Эзэн дотор” дуулгавартай байх гэсэн болохоос биш эрэгтэй нь эмэгтэй хүнийг хүчээр эзэрхийлэн түрэмгийлэх, хүчирхийлэх, үнэний эсрэг ямар нэгэн зүйлийг хий гэхэд эмэгтэй хүн дагах ёстой гэсэн үг биш юм. Тэглээ ч гэсэн эмэгтэй хүн “Эзэн дотор” өөрийн байр сууриа ухамсарлаж байх хэрэгтэй билээ. Эхнэр нь нөхрөө чин сэтгэлээсээ хайрлан ямар ч үед нөхрийнхөө зүрх сэтгэлд нь тааруулан үйлчлэх ёстой юм. Тэгвэл нөхөр нь ч гэсэн эхнэрийнхээ зүрх сэтгэлийг үйлчлэлээр нь дамжуулан мэдрэх болдог. Энэ мэт эхнэр нь нөхөртөө алив сайн бүхнээр харьцан, дотноор үйлчилбэл ямар ч хатуу зүрх сэтгэлтэй нөхөр нь ч эцэстээ ихэнх нь зүрх сэтгэл нь зөөлөрдөг билээ

Нэмж хэлэхэд, эхнэр нь нөхрийнхөө санал бодлыг хүндэтгэн, идэвхитэйгээр дэмжих үед л тухайн гэр бүлд жинхэнэ дэг журам төгс болох билээ. Ингэвэл нөхөр нь ч гэсэн өрхийн тэргүүний хувьд илүү их урамшин гэр бүлийнхээ төлөө үүргээ сайн гүйцэтгэдэг билээ. Гэхдээ эхнэр нь нөхрөө үл хүндэтгэсэн үйлс, үг яриа ба аар саар зүйлээр урамыг хугалбал тэр гэр бүлд асуудал тасрахгүй өөр хоорондоо үл ойлголцдог болохыг санах хэрэгтэй билээ.

Доктор И Жаерок пасторын  
“Эхлэл бүлгийн тайлбар” сургаалын хэсгээс  
(www.manmin.org)